



БАТЛАВ
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА




Ж.ЦОЛМОН

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН
ШАЛГАХ АЛБАНЫ ЗАВСРЫН МЭДЭГДЭЛ
ГАРГАХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-11		
Баталсан огноо:	2025 он- 11 сар- 28 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр Х. Нарангун	Огноо 2025.11.27	Гарын үсэг 
Боловсруулсан:	Албан тушаал, нэр Н. Бэрэншан	Огноо 2025.11.27	Гарын үсэг 

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Мурман	Бүрэг	ш/ш	2025. 11.20	

Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Мурман	ш/ш карт
2		
3		

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ
АЛБАНЫ ЗАВСРЫН МЭДЭГДЭЛ ГАРГАХ ЖУРАМ

1. Журмын зорилго

Энэхүү журмын зорилго нь агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайлан 12 сарын дотор бэлэн болоогүй тохиолдолд завсрын мэдэгдэл боловсруулах, батлах, нийтэд мэдээлэх, бүртгэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжлэн шалгаж буй осол, ноцтой зөрчлийн бүх тохиолдолд шинжлэнэ.

3. Эрх зүйн үндэслэл

Энэхүү журам нь ICAO Annex 13, холбогдох үндэсний хууль тогтоомж, иргэний нисэхийн дүрэм, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгахтай холбоотой бусад эрх зүйн актад үндэслэнэ. Annex 13-ын дагуу final report 12 сарын дотор нийтлэгдээгүй бол тухайн тохиолдлын ой бүр шинжлэн шалгалтын явц болон safety issue-ийг тусгасан interim statement гаргана.

4. Нэр томьёо

“Завсрын мэдэгдэл” гэж шинжлэн шалгалт үргэлжилж байгаа бөгөөд эцсийн тайлан хараахан батлагдаагүй үед шинжлэн шалгалтын явц, хийгдсэн ажил, цаашдын төлөвлөгөө, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлыг нэгтгэн олон нийтэд мэдээлэх албан ёсны баримт бичгийг хэлнэ.

5.Завсрын мэдэгдэл гаргах үндэслэл

Дараах тохиолдолд завсрын мэдэгдэл гаргана: 1) осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгалт эхэлснээс хойш 12 сар өнгөрсөн боловч эцсийн тайлан батлагдаагүй; 2) эцсийн тайлан батлагдах хүртэл тухайн тохиолдлын ой бүрээр дахин гаргана.

6.Хариуцах албан тушаалтан

Завсрын мэдэгдлийн төслийг шинжлэн шалгах багийн ахлагч боловсруулж, холбогдох шинжлэн шалгагч нар саналаа өгч, албаны дарга батална.

7.Хугацааны хяналт

Шинжлэн шалгах хэрэг бүр дээр 10, 11, 12 дахь сарын хяналтын тэмдэглэл хөтөлнө. Эцсийн тайлан 12 сарын дотор гарах боломжгүй гэж үзвэл 11 дэх сараас завсрын мэдэгдлийн төслийг боловсруулж эхэлнэ.

8. Мэдэгдэл боловсруулах эх үүсвэр

Завсрын мэдэгдлийг дараах материалд үндэслэн боловсруулна:

- 1) шинжлэн шалгалтын явцын тайлан;
- 2) үзлэг, шинжилгээний дүн;
- 3) лаборатори, техникийн дүгнэлт;
- 4) холбогдох улс, байгууллагын мэдээлэл;
- 5) гарсан safety recommendation;
- 6) шинжлэн шалгалтын багийн хурлын тэмдэглэл.

9. Завсрын мэдэгдэл нь дараах үндсэн хэсэгтэй байна:

- 1) гарчиг;
- 2) тохиолдлын дугаар;
- 3) осол/ноцтой зөрчлийн огноо, газар;
- 4) агаарын хөлгийн мэдээлэл;
- 5) шинжлэн шалгалтын өнөөгийн байдал;
- 6) хийгдсэн гол ажил;
- 7) аюулгүй ажиллагаатай холбоотой гол асуудал;
- 8) цаашдын ажил;
- 9) нийтэлсэн огноо.

10. Завсрын мэдэгдэлд шинжлэн шалгалтын бодит явц, хийгдсэн ажиллагаа, дутуу байгаа шинжилгээ, урьдчилсан байдлаар анхаарал татаж буй аюулгүй ажиллагааны асуудал, шаардлагатай бол гаргасан аюулгүй ажиллагааны зөвлөмжийг тусгана.

11. Завсрын мэдэгдэлд эцэслэн тогтоогдоогүй шалтгаан, буруутгал, иргэн/хуулийн этгээдийн хариуцлагын дүгнэлт, нууцад хамаарах мэдээлэл, хамгаалагдсан мэдүүлэг болон хуульд өөрөөр хориглосон мэдээллийг тусгахгүй.

12. Төслийг шинжлэн шалгах баг дотоод хэлэлцүүлгээр авч үзэж, баримтын нийцэл, хэл найруулга, нууцлал, олон нийтэд мэдээлэх боломжийг шалгана. Шаардлагатай бол хууль, чанарын асуудал хариуцсан ажилтнаар нэмэлт хяналт хийлгэнэ.

13. Завсрын мэдэгдлийг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дарга батална. Батлагдсан хувилбар нь албан хэрэг хөтлөлтийн дугаар авч бүртгэгдэнэ.

14. Батлагдсан завсрын мэдэгдлийг байгууллагын цахим хуудас, албан ёсны мэдээллийн сувгаар нийтэд мэдээлнэ. Шаардлагатай тохиолдолд ICAO-д хүргүүлэх мэдээг холбогдох тайлагналын сувгаар илгээнэ.

15. Завсрын мэдэгдлийн батлагдсан эх хувь, нийтэлсэн огнооны нотолгоо, илгээсэн бүртгэл, холбогдох хавсралтыг хэрэг тус бүрийн шинжлэн шалгах материалд хадгална.

16. Энэхүү журмын хэрэгжилтэд Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дарга хяналт тавина.